

## **Улаанбаатар хотын Захиргаа**

1932 оны 8 дугаар сарын 22-онд Сайд нарын Зөвлөлийн 9 дугаар хурлын 3 дугаар зүйлээр Төв аймаг, Улаанбаатар хотын захиргааг салгаж байгуулахаар шийдвэрлэсэн юм.

1938 оны 04 дүгээр сарын 1-энд Сн3-ийн хурлаар хот сайжруулах комиссын төслийг хэлэлцээд баталсан.

1939 оны 3 сард улсын 22 дугаар бага хурлын тогтоолоор “хотыг захирах яам” хэмээн нэрлэхийг “Улаанбаатар хотын захиргаа” хэмээн нэрлэх болсон.

1940 онд батлагдсан БНМАУ-ын үндсэн хуулиар “Улаанбаатар хотын бага хурлын тэргүүлэгчид” хэмээн тогтоосон.

1940-10-3-анд Сайд нарын Зөвлөлийн 50-р хурлын 8-р зүйлээр Улаанбаатар хотын хөдөлмөрчин ардын хурал ба хотын захиргааны дүрмийг баталжээ.

Шинэчлэгдсэн дүрэмд Бусад зүйлийг заахдаа харьяат хотыг захирах, дээд газраас гаргасан хууль, дүрэм, тогтоол, тушаалыг биелүүлэх хотын дотор журам, байдлыг сахиулах, хотын дотор хи аж ахуй, үйлдвэр, худалдаа, соёлын байгууллагыг удирдаж, зохистой хөгжүүлэх, ард түмний соёл, бичгийн үсгийн мэдлэгийг дээшлүүлэх, ариун цэвэр, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг шууд авч явуулна.

Мөн улсын бага хурлын тэргүүлэгчид /Сайд нарын Зөвлөл/ олон яамд зэрэг төв байгууллагуудаас дагаж шийтгүүлэн байгаа хууль дүрэм, тогтоол тушаалуудад нийцүүлэн хотын хэмжээнд дээр ерөнхий удирдлага өгч харьялагдах албан газруудын ажилд хяналт тавих, ард иргэдийн эрх үүргийг хамгаалах, хот орчныг хөгжүүлэх талаар холбогдсон нэлээд шинэ үүрэг заасан байна.